

Цэцэрлэгийн Насныханд

Библи Судлалын Хичээл

Библи Судлалын Шаббат хичээлийн Цэцэрлэгийн насныханд зориулсан сурах бичиг
Грейс Линк Шаббат хичээлийн сургалтын хөтөлбөр

Хоёр дахь жил, Дөрөвдүгээр улирал

РЕДАКТОР

ТУСЛАХ РЕДАКТОР

ГРЕЙС ЛИНКИЙН СУРГАЛТЫН

ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАГЧ

ДЭЛХИЙН ШАББАТ ХИЧЭЭЛИЙН УДИРДАГЧ

ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ ЗӨВЛӨХ

ЗӨВЛӨХ РЕДАКТОР

ЗУРГИЙН ДАРГА/ДИЗАЙНЕР

ДИЗАЙНЕР

КОМПЬЮТЕР ТЕХНИКЧ

ЗАХИАЛГЫН АЛБА

НОМЫН ЗУРААЧ

ЛАЙН АРТ ЗУРААЧ

ПАТРИШИА А. ХАБАДА

ЛИЗА РАСМУССЕН

ПАТРИШИА А. ХАБАДА

ЖЕЙМС В. ЗАКРИСОН

ЛОУЭЛЛ С. КУПЕР

АНЖЕЛ М. РОДРИГЕС

ТРЕНТ ТРУМАН

МАДЕЛИН ГАЦ

ШИРЛЕЙ М. БОЛИВАР

СТИВ ХЕНСОН

ДЕН ШАРП

МАРИ БОСМАН

Шаббат хичээл ба Үйлчлэлийн албанаас гаргасан хэвлэл

Долоо дахь өдрийн Адвентистуудын Ерөнхий Чуулган

12501 Old Columbia Pike

Silver Spring, MD 20904-6600, USA

Текстийг New International Version-ны Ариун Библи орчуулгаас авч Зондерван Библийн Хэвлэлийн газрын зөвшөөрлөөр ашиглав. Зохиогчийн эрх* 1973, 1978, 1984, Олон Улсын Библийн Нийгэмлэг.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

ОРЧУУЛСАН:

ХЯНАСАН:

ЭХ БЭЛТГЭСЭН:

М. ЭНХБАЯР

Ц. САЙНХҮҮ

П. БОЛОРМАА

Ж. ПҮРЭВДУЛАМ

Библиэс ишлэл татахдаа Монголын Библийн Орчуулгын Холбооноос 2000 онд эрхлэн гаргасан “Ариун Библи” номыг ашиглав.

Жоли Пресс® Хэвлэлийн газар
Улаанбаатар 2008

“ЦЭЦЭРЛЭТИЙН НАСНЫХАНД” НОМЫН ЗОХИОГЧИД

Одри Боил Андерсон	Швед	Донна Меадор	Вашингтон
Жекль Бишол	Колорадо	Викки Монтгомери	Мариланд
ДиАнн Брагав	Колорадо	Ребека О Фил	Мариланд
Линда Портер Карлиль	Орегон	Эвелин Омана	Венесуел
Хелга Айтенийр	Герман	Денис Переира	Калифорни
Рене Алексенко Эванс	Тенниси	Дон Рейнолдс	Мариланд
Адрина Итин Фемопасе	Аргентин	Жанет Ригер	Австрали
Рене Гарригес-Гудвин	Вашингтон	Жуди Рожерс	Мариланд
Ферил Харрис	Баруун Виржиниа	Денис Ропка-Касишке	Калифорни
Айлин Дол Вермер		Канад	

Талархал . . .

Энэхүү Грейс Линкийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлыг санаачлан гүйцэтгэсэн Ла Сиерра Их Сургуулийн Залуучуудад үйлчлэх Жон Ханкок Төвийн Бейли Гиллеспи болон Стюарт Тайнер нарт талархаж буйгаа илэрхийлье.

Гарчит

ЭВ НЭГДЭЛ

Бид бие биедээ хайраар ханддаг.

1. Шинэ Нөхөд9
2. Онцгой Долоон Туслагч13
3. Хоёр Хүн ба Хачирхалтай Мэдээ17
4. Шоронд Орсон нь бас Гарсан нь21

ҮЙЛЧЛЭЛ

Бид бусдад өгч үйлчилдэг.

5. Тусламжийн Гар25
6. Сохор Хүн Удирдаж Сурав29
7. Манай Гэрт Хүрээд Ир33
8. Шоронгийн Магтаал37
9. Усан Онгоц Сүйрэв41

ӨРШӨӨЛ ЭНЭРЭЛ

Бурханы ивээл бол Түүний өгсөн бэлэг.

10. Бурханы Үг41
11. Бурханы Элч Нар45
12. Хамгийн Сайхан Бэлэг49
13. Бурханд Зориулсан нь53
14. Тэр Дахин Ирнэ57

Хүүхдийн Нийтлэг Хэрэгцээ*

Хүүхэд бүхэнд шаардлагатай нийтлэг хэрэгцээ байхаас гадна нас, хөгжлийнх нь онцлогт тохирсон өвөрмөц хэрэгцээ гэж байдаг.

Бие Махбодь

- Хоол тэжээл
- Халуун дулаан хандлага
- Орон гэр

Оюун Ухаан

- Сонголт хийж, төлөвлөгөө дагах чадвар

Сэтгэл Хөдлөл

- Хэн нэгэнд хамааралтай гэдгээ мэддэг байх
- Дэмжлэг авах үнэлэгдэх
- Амиа үл хичээх хайр, бусдыг хүлээн зөвшөөрөх
- Өөр өөр нөхцөл байдалд чөлөөтэй байх
- Хөгжих байдал—инээж баясах боломжоор хангагдах

Итгэл Бишрэл

- Бурхан бол бүхнийг мэддэг, хайрладаг, халамжилдаг
- Буруу зүйлийг уучилж, шинээр эхлэх боломж олгодог
- Бурхан өөрсдийг нь хүлээн зөвшөөрдөг гэсэн итгэлтэй байх
- Тогтмол залбирдаг байх, залбирлын хариуг мэдрэх
- Бурханы тухай мэдлэг, өршөөл энэрэл дор өсөх боломжоор хангагдах

Цэцэрлэгийн Насны Хүүхэд

Долоо дахь өдрийн Адвентист сүмд 3-5 насны хүүхдүүдийг Цэцэрлэгийн насны Шаббат хичээлд хамруулдаг. Гэхдээ хүүхэд бүрийн онцлог өөр өөр байдаг учраас Шаббат хичээлийн ангийн хүүхэд тус бүрийн хичээлийн талаарх мэдлэг чухал юм. 3-5 насны хүүхдийн ерөнхий онцлог байдлыг доор бичлээ.

Бие Махбодь

- Ерөнхий том булчингийн хөгжил эхэлдэг
- Тэнцвэрийн талаар ойлголт багатай
- Маш хөдөлгөөнтэй
- Амархан ядардаг ч хэсэгхэн амраад л сэргэдэг
- Ерөнхий булчингийн хөдөлгөөн сул
- Сониуч, орчин тойрноо таних хүсэлтэй
- Нээж олсон зүйлээсээ суралцдаг

Оюун Ухаан


- Харж байгаа юмыг нь тайлбарлаж өгөхгүй бол сонсоод ойлгох чадвар муу
- Тогтоолт хурдан
- Ойлгохгүй зүйлээ ч тогтоодог

Сэтгэл Хөдлөл

- Амархан уйлдаг
- Сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлж чадна
- Тэнцвэрийг алдуулалгүйгээр хүссэн зүйлээ дараа гүйцэлдүүлэхээр хойшлуулж сурдаг
- Сөрөг сэтгэгдлээ илэрхийлж сурдаг

Нийгэм/Бусадтай Харилцах Байдал

- Эргэн тойронд олон хүн байвч, амиа хичээх байдалтай
- Найзтайгаа тоглохын оронд өөрөө өөртэйгөө тоглодог
- Найзтай болох тэдэнтэй хамт байх дуртай



Хөгжлийн Хэрэгцээ

Дээр дурьдсан хэрэгцээнээс гадна дараах зүйлс цэцэрлэгийн насны хүүхдүүдэд шаардлагатай:

- Өөрийн хүрээндээ сонголт хийх, танин мэдэх, эрх чөлөөтэй байх
- Бие даан суралцах эрх мэдэл
- Эцэг эх, багш нарын тогтоосон хил хязгаар
- Тоглож наадахдаа суралцах боломж
- Аюулгүй мөн амьдралаа зөв бүтээх сахилга батад сургах

Итгэл Бишрэлийн Хэрэгцээ

Цэцэрлэгийн насны хүүхдүүд дараах зүйлсэд суралцах ёстой:

- Эзэн Бурхан тэднийг хайрлаж халамжилдаг.
- Эзэн Бурханыг хэрхэн хүндлэх вэ?
- Эзэн Бурхан тэднийг бүтээсэн учраас тэднийг сайн мэддэг, тэднийг үнэлдэг
- Зөв буруугийн ялгаа
- Эзэн Бурханы тусламжтайгаар хэрхэн зөв сонголт хийх вэ?


Ерөнхий Дүрэм

Хүүхдийн анхаарал төвлөрөлт нас ахих тутам 1 минутаар нэмэгддэг. 3 настай хүүхдийн анхаарал төвлөрөлт ойролцоогоор 4 минут тул аль болох тэдэнд сонирхолтой байлгах хэрэгтэй.

Цэцэрлэгийн Насны Хүүхэд:

- Сонирхолтой байдлаар давтахад дуртай
- Ерөнхийлөн дүгнэлт гаргаж сурдаг
- Энгийн зүйлсээс эхлэн зорилготой байхад суралцана—ихэвчлэн буруу аргаар
- Идэвхтэй оролцооны үндсэн дээр яг зөв зүйлээс суралцана
- 3-6 минутын хооронд анхаарал төвлөрнө

*Хүүхдийн үйлчлэл: Үр бүтээлтэй санаа ба арга техникүүд (Lincoln, Nebr.: AdventSource, 1997).



Эцэг Эхчүүдэд Зориулсан Захидал

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Цэцэрлэгийн насныханд зориулсан Грейс Линкийн Библи Судлалын сурах бичиг маань бэлэн боллоо. Дэлхийн эргэн тойронд маш олон эрдэмтэн зохиолч, номын техникийн ажилчдын 4 жилийн хөдөлмөр дадлага туршлага хичээл зүтгэлийн үр дүнд бий болсон энэхүү ном та бүхний гар дээр очиж байна.

Цэцэрлэгийн насныханд зориулсан Грейс Линкийн хичээлүүд нь та бүхнийг Шаббат хичээлтэй танилцуулах бөгөөд Библийн энэхүү сурах бичиг нь та нарын өдөр тутмын мэдлэгийг улам дээшлүүлж сайжруулахын тулд зориулагдсан юм. Дасгал ажил гэсэн дасгалууд маань гэр бүлийн Бурханыг хайрладаг, хүндэлдэг сэтгэлийн угаас зохиогдож хийгдсэн юм шүү.

Ямар ч үед та үр хүүхдүүдтэйгээ эдгээр дасгалуудыг цуг хийснээр та болон таны хүүхдүүд уйдаггүй маш тааламжтай сайхан сэтгэгдлийг авах болно. Дасгал ажлыг хийхэд ашигласан материалууд танай гэр оронд байж л байдаг энгийн зүйлүүд. Гэсэн хэдий ч та энэ сурах бичгийг хэрэглэхээсээ өмнө хэрэгтэй материалуудын жагсаалтыг номноосоо эхлээд хараарай.

Өдөрт хийгдэх дасгалуудын ихэнх нь Библи уншихад уриалсан болохыг ажиглах болно. Хүүхдүүдийн сонсож байгаа түүх нь Бурханы үг болох Библийн номноо бичигдсэн гэдгийг хүүхдүүд ойлгох цаг нь болсон. Та хичээлийн өмнөх унших хэсэгт бичигдсэн Библийн сургаалаас авсан хэсгүүдэд анхаарлаа хандуулаарай. Таны хүүхэд өсөж том болохын хэрээр та тэдэнд Библиэ яаж уншиж ойлгож болохыг зааж өгөөрэй. Бурханы бүтээсэн энэхүү дэлхийтэй болгоомжтой хандахад хүүхдэдээ туслах, чиглүүлэх цаг нь нэгэнтээ болжээ.

Та бүхэн боломж л гарвал хүүхдийн хамтаар Бурхандаа залбирч байгаарай. Бас энэ залбиралдаа биднийг багтаахаа бүү мартаарай. Нэг нэгнийхээ төлөө хамтдаа залбиран хүүхдүүдээ Есүс Христийн замаар дагуулан явцгаая.

**Хүндэтгэн ёсолсон,
Зохиогчид**